



## ДҮРС ОНОШИЛГОО СУДЛАЛ

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Мэргэшлийн чиглэлээр эрдэм шинжилгээний хурлын илтгэл ажиллах явцдаа жилд 1-ээс доошгүй удаа буюу нийт 8-аас доошгүйг бичиж хэвлүүлсэн байх /гадаад болон дотоод, илтгэлийн хураангуй байх, хэвлүүлсэн ном, сэтгүүлийн хуулбар хавсаргах/;
2. Сургалт эрхлэх байгууллагаас зохион байгуулсан /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/ мэргэшлийн чиглэлийн хурал, семинарт сүүлийн 5 жил тасралтгүй хамрагдсан байх /гэрчилгээний хуулбараар баталгаажуулах/;
3. Дүрс оношилгооны чиглэлээр мэргэшил дээшлүүлэх сургалтад 1 сараас доошгүй хугацаанд хамрагдсан байх /сургалт эрхлэх эрх бүхий байгууллагын гэрчилгээний хуулбараар баталгаажуулах/.

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Сургалт эрхлэх байгууллагаас зохион байгуулсан /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/ мэргэшлийн чиглэлийн хурал, семинарт ахлах зэрэг хамгаалснаас хойш 5 жил тасралтгүй хамрагдсан байх, гэрчилгээний хуулбараар баталгаажуулах;
2. Оношилгоо, эмчилгээний стандарт, удирдамж боловсруулах багт ажилласан байх /3-с доошгүй/, хуулбараар баталгаажуулах;
3. Эрдэм шинжилгээний хурлын илтгэл /гадаад болон дотоод илтгэлийн хураангуй/ ажиллах хугацаандаа жилд 1-ээс доошгүй удаа буюу ахлах зэрэг хамгаалснаас хойш 5-аас доошгүйг бичиж хэвлүүлсэн байх, илтгэлийн хураангуй, хэвлүүлсэн номын хуулбараар баталгаажуулах;
4. Үндэсний хэмжээний сургалт, семинар зохион байгуулахад оролцсон байх, баталгаажуулах;
5. Дүрс оношилгооны чиглэлээр төгсөлтийн өмнөх болон дараах сургалт, дадлагын үйл ажиллагааг удирдсан байх, байгууллагын тушаалаар

Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн  
2020 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн  
12 дугаар тогтоолын хавсралт

баталгаажуулсан байх /орон нутагт ажиллаж буй эмнэлгийн мэргэжилтний тухайд залуу эмч нарыг шавилан сургасан, урьдчилан сэргийлэх болон оношилгооны чиглэлээр эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулан, сургалт удирдсан байх /;

6. Дүрс оношилгооны чиглэлээр төрөлжсөн мэргэшил эзэмшсэн байх, /гэрчилгээгээр баталгаажуулах/.

**ЗӨВЛӨХ** зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Тэргүүлэх зэрэг хамгаалснаас хойш 5-аас доошгүй жил тасралтгүй ажилласан байх, албан газрын тодорхойлолт нийгмийн даатгалын хуулбараар баталгаажуулах;
2. Мэргэшлийн чиглэлээр олон улсын болон үндэсний хурал, семинар, чуулган зохион байгуулсан болон хурал удирдаж байсан, хуулбараар баталгаажуулах;
3. Оношилгоо эмчилгээний стандарт 3-аас доошгүйг боловсруулсан байх, ном, гарын авлага, удирдамж 3-аас доошгүй бичиж туурвисан байх, /хуулбараар баталгаажуулах/;
4. Эрдэм шинжилгээний хурлын илтгэл /гадаад болон дотоод илтгэлийн хураангуй 20-аас доошгүй байх/ хуулбараар баталгаажуулах;
5. Дүрс оношилгооны чиглэлээр төгсөлтийн дараах сургалт, дадлагын үйл ажиллагааг удирдсан байх, байгууллагын тушаалаар баталгаажуулсан байх /орон нутагт ажиллаж буй эмнэлгийн мэргэжилтний тухайд залуу эмч нарыг шавилан сургасан, урьдчилан сэргийлэх болон оношилгооны чиглэлээр эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулан, сургалт удирдсан байх.